



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 1190

Мандалговь

Сайнцагаан сумын борлуулалтын цэгийн тоног  
төхөөрөмж хүлээж авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журмын 4.3.4 дүгээр заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй “Сайнцагаан сумын борлуулалтын цэгийн тоног төхөөрөмж” нийлүүлэх ажлыг хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Ц.Лхагвасүрэн (Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд:

Э.Мөнхзул (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Ж.Батбилэг (Хүнс, хөдөө аж ахуйн газрын мал үржлийн албаны дарга)

О.Мөнхбат (Борлуулалтын цэгийн менежер)

Нарийн бичгийн дарга:

Э.Сүхбат (Тэлмэн нетворк ХХК-ний захирал)

2. Сайнцагаан сумын борлуулалтын цэгийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ажиллахыг комиссын дарга (Б.Лхагвасүрэн)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  П.ДОРЖБАТ



1152405